



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 08

Сангивдалай

Сумын 2025 оны Газар зохион байгуулалтын
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь хэсгийг үндэслэн, Сумын " 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө"-ний төслийг хэлэлцээд ТОГТООХ НЬ:

1. Сумын 2025 оны "Газар зохион байгуулалтын төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2. Газрын багц хуулиудыг олон нийтэд өргөн сурталчилж "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх" ажлыг эрчимжүүлэх, газрын төлбөр ногдуулах, хуримтлуулах ажлыг сайжруулах замаар газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, үр өгөөжийг дээшлүүлэхэд анхаарч "Газар зохион байгуулалтын биелэлт"-ийн талаар мэдээлж ажиллахыг сумын Засаг дарга (С.Мөнхбаатар), газрын даамал (Э.Ууганцэцэг) нарт үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороодод даалгасугай.

ДАРГА



Ш.СҮХБАЯР